



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/64

Номгон

Эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2023 оны A/130 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баянхонгор аймгийн 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жаргаалтад тусгагдсан “Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Баасанбат  
(Газар зохион байгуулалт, инженерийн шугам сүлжээ, зам талбай хариуцсан ажилтан)

Гишүүд П.Баатар  
(Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ж.Цогтбаяр  
(Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын менежер)

Нарийн бичгийн дарга Н.Цэдэвсүрэн  
(Иргэний төлөөлөл)  
Н.Пүрэвжаргал  
(Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Тендерийн материалыг үндэслэл сайтай боловсруулж, хууль журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, ашиг сонирхлын зөрчилгүй үнэлгээний хорооны гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, зөвлөмжийг өргөн мэдүүлэхийг үнэлгээний хорооны дарга (Ц.Баасанбат)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА  Г.ЭНХБАЯР